



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 2 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 45

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт үүрэг болгосугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын Шадар сайд

С.АМАРСАЙХАН



Засгийн газрын 2021 оны 45 дугаар
тогтоолын хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАРХАЛТЫН ТҮВШИНГ ТОГТООЖ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын (цаашид “халдвар” гэх) тархалтын түвшинг тогтоож, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, халдварын тархалтын түвшинтэй уялдуулан төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Халдварын тархалтын түвшинтэй уялдуулан төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулахдаа тухайн нөхцөлд тохируулан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгийн бага хязгаарлах, эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах зарчим баримтална.

1.3.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг тогтоохдоо халдварын тархалтын түвшин, нийгэм, эдийн засгийн болон бусад нөхцөл байдалд үндэслэнэ.

1.4.“Халдварын тархалтын түвшин”-г энэ журмын 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.1.4-т заасан шалгуур үзүүлэлтийн үр дүнг үндэслэн тодорхойлно.

Хоёр.Халдварын тархалтын түвшин

2.1.Халдварын тархалт нь дараахь түвшинтэй байна:

2.1.1. “Ногоон түвшин” (халдвар илрээгүй):

Шалгуур үзүүлэлт: -Сүүлийн 28 хоногийн хугацаанд шинээр халдвар бүртгэгдээгүй байх.

2.1.2. “Шар түвшин” (зөөвөрлөгдсөн, алаг цоог тархалттай):

Шалгуур үзүүлэлт: -Сүүлийн 14 хоногийн хугацаанд бүртгэгдсэн болон зөөвөрлөгдөн ирсэн тохиолдол нь цаг хугацаа, газар зүйн байршил, тархвар судлалын хувьд хоорондоо холбоогүй байх.

2.1.3. “Улбар шар түвшин” (халдвар голомтот тархалттай):

Шалгуур үзүүлэлт: -Сүүлийн 14 хоногийн хугацаанд бүртгэгдсэн тохиолдол болон голомт нь цаг хугацаа, газар зүйн байршил, тархвар судлалын хувьд хоорондоо холбоотой, тодорхой хүн амын хүрээнд хязгаарлагдсан байх.

2.1.4. “Улаан түвшин” (халдвар хүн амын дунд өргөн тархалттай):

Шалгуур үзүүлэлт: -Сүүлийн 14 хоногт бүртгэгдсэн тохиолдол нийт хүн амын дунд тархсан байх;

-Шинээр батлагдсан тохиолдлын 25-аас дээш хувьд халдварын эх үүсвэр тодорхойгүй буюу тархвар зүйн холбоогүй байх;

-10000 хүн ам тутамд өвчлөлийн түвшин 5.1-ээс их байх;

-“ПГУ” шинжилгээний эерэг илэрсэн хувь 2.1-ээс их байх;

-10000 хүн ам тутамд эмнэлэгт хэвтэлтийн түвшин 5-аас их байх;

-10000 хүн ам тутамд нас баралтын түвшин 0.1-ээс их байх.

Гурав.Удирдлага, зохион байгуулалт

3.1.Халдварын судалгаа, өвчний мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, тандалтын тоон мэдээнд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн халдварын тархалтын түвшинг Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, тухайн шатны эрүүл мэндийн байгууллага тодорхойлж, саналаа Улсын онцгой комисст хүргүүлнэ.

3.2.Энэ журмын 3.1-д заасан байгууллага халдварын тархалтын түвшинг 7 хоног тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүрт тогтоосон аргачлалаар үнэлж, түвшинг өөрчлөх тухай саналаа Улсын онцгой комисст хүргүүлнэ.

3.3.Халдварын тархалтын байдал, эрсдэлийн үнэлгээний дүн, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, орон нутгийн онцлог, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний чадавхаас хамаарч халдварын тархалтын түвшинг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд тогтоох, өөрчлөх шийдвэрийг Улсын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу тухайн шатны Онцгой комисс гаргана.

3.4.Засгийн газраас тогтоосон гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгтэй уялдуулан улсын хэмжээнд, эсхүл нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт халдварын тархалтын түвшинг тогтоох, өөрчлөх шийдвэрийг Улсын онцгой комисс гаргана.

Дөрөв.Халдварын тархалтын түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1.Халдварын тархалтын түвшинтэй уялдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн шатны Засаг дарга биечлэн хариуцаж, зохион байгуулна.

4.2.“Ногоон түвшин”-д төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлахгүй, нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

4.3.“Шар болон Улбар шар түвшин”-д “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар шилжүүлж, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тодорхой хүрээнд хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм тогтооно.

4.4. “Улаан түвшин”-д “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар шилжүүлж, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлаж, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмийг тогтооно.

4.5. Халдварын тархалтын түвшин бүрт төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг энэ журмын хавсралтад заасан горимоор зохицуулна.

4.6. Төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд нь энэ журмын хавсралтад заасан горимын дагуу үйл ажиллагаа явуулахдаа “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ыг мөрдөж, тусгай нөхцөл, шаардлагыг биелүүлж ажиллана.

Тав.Хариуцлага

5.1. Энэ журмыг зөрчсөн төрийн байгууллага, түүний удирдлага, албан тушаалтан, ажилтан, хүн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журмын хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

Зэрэглэл	Өдөр тутмын бэлэн байдал		Өндөржүүлсэн бэлэн байдал		Бүх нийтийн бэлэн байдал
	I	II	III	IV	
Түвшин	Халдвар илрээгүй	Зөөвөрлөгдсөн, алаг цоог тархалттай	Халдвар голломтот тархалттай		Халдвар хуугамын дунд тархсан
Төрийн байгууллага	Халдвараас сэргийлэх дэглэм сахиулах	1. Уралдаан тэмцээн, аялал зугаалга	<p>Хязгаарлах үйл ажиллагаа</p> <p>1. Бүх төрлийн баяр ёслол, тэмдэглэлт ойн арга хэмжээ, хурал, цуглаан, цайллага, хүлээн авалт; 2. Олимп, тив, дэлхий, олон улсын тэмцээний бэлтгэлээс бусад биеийн тамир, спортын үйл ажиллагаа (дотоод орчинд 10-аас дээш хүн); 3. Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаа.</p>		<p>Хязгаарлахгүй үйл ажиллагаа</p> <p>1. Хууль тогтоох, төрийн захиргааны байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Авлигатай тэмцэх газар, Сонгуулийн ерөнхий хороо (нийт ажилтан, албан хаагчийн 10 хүртэл хувь ажиллах, цагийн хязгаар тогтоох); 2. Эрүүл мэндийн байгууллага; 3. Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд (Байгаль орчныг хамгаалах, гааль, дипломат алба, онцгой байдал, мэргэжлийн хяналт, зэвсэгт хүчин бусад цэрэг, татвар, тусгай алба, гадаадын иргэн, харьяат, улсын бүртгэл, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх); 4. Шүүх, прокурор, өмгөөлөл, нотариат; 5. Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллага (тусгай цагийн хуваарьтай ажиллах, Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолыг</p>

				баримтлах); 6. "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудал, "МИАТ" ТӨХК; 7. Эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгал, нийтийн аж ахуй; 8. Шуудан, харилцаа холбоо; 9. Шатахуун, түлшний үйлдвэрлэл, хангамж, нийлүүлэлт, түгээлт, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын түлшний тээвэрлэлт, худалдаа; 10. Геологи, хайгуул, уул уурхай, газрын тосны олборлолт; 11. Зайны сургалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ, асрамж, халамж, түр хамгаалах байр, Монголын улаан загалмай нийгэмлэг; 12. Цахим банк, автомат тооцооны машин; 13. Газар тариалан, мал, амьтны өвс, тэжээлийн түгээлт, тээвэрлэлт.
--	--	--	--	--

Тайлбар: Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагыг Улсын онцгой комисстой зөвшилцсөнөөр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

Хязгаарлалтаас хамаарч тавигдах шаардлага				
Ажиллах горим	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	-Нэг дор 30-аас дээш хүн цугларахгүй байх (2 метрээс доошгүй зай барих)	-Нэг дор 10-аас дээш хүн цугларахгүй байх (2 метрээс доошгүй зай барих)	-Ажилдаа ирэх, явах; -Ажил, үүрэг гүйцэтгэх; -Засвар үйлчилгээ; -Үйлдвэрлэл, түгээлтийг зөвшөөрнө.
Хөдөлгөөнд оролцох цагийн горим	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	07.00-00.00	07.00-22.00	08.30-18.00
Нийтийн тээврийн хэрэгсэл	-Ердийн цагийн хуваариар -Халдвар хамгааллын дэглэм сахих	-Ердийн цагийн хуваариар; -Халдвар хамгааллын дэглэм сахих	-1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Хүн хоорондын зай бариулах; -Халдвар хамгааллын дэглэм сахиулах.	-Онцгой комиссын зөвшөөрсөн чиглэлд; -Цагийн хуваарийг тусгай горимд шилжүүлэх; -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахиулах.

Автомашин	-Автомашинны улсын дугаарын хязгаарлалтын дагуу зорчих (зөвхөн нийслэлд)	-Хязгаарлалтад хамаарахгүй байгууллагын ажилтан, албан хаагчид ажлын үнэмлэхтэй	-Хязгаарлалтад хамаарахгүй байгууллагын ажилтан, албан хаагчид байгууллагын тодорхойлолт, ажлын үнэмлэхтэй
Хот хоорондын зорчигч тээвэр (төмөр зам, авто зам)	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	-Ердийн цагийн хуваариар -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Халдвар хамгааллын дэглэм сахиулах.	-Онцгой комиссын зөвшөөрөлтэй; -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахиулах.
Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	-Орох, гарах тээврийн хэрэгслийг хязгаарлах; -Халдварын тархалт бүртгэгдсэн газраас "ПГУ" шинжилгээний хариуг үндэслэн нэвтрүүлэх; -Голомтгүй бүсээс асуумж авч нэвтрүүлэх.	-Албан томилолт, зайлшгүй шаардлагатай тээврийн хэрэгслийг улс, аймаг, нийслэлийн Онцгой комиссын шийдвэрээр нэвтрүүлэх
Агаарын хил, авто зам, төмөр замын боомт	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	Олон улсын болон дамжин өнгөрөх ачаа тээвэр, гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн гадаадад зорчих Монгол Улсын иргэд, гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын ажилтан, тэдний гэр бүлийн гишүүд, хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх албан айлчлал, уулзалт, арга хэмжээний төлөөлөгчдийн хөдөлгөөнийг Улсын онцгой комиссын шийдвэрээр зөвшөөрөх	-Ажлын тусгай горимд шилжүүлэх (уртасгасан, богиносгосон цаг, цахимаар, ээлжээр ажиллах); -Мэргэжлийн байгууллагын зөвлөмж, шаардлагыг баримтлах; -Байгууллага дээр "QR" код байршуулан ажилтан, албан хаагч, зайлшгүй шаардлагаар үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх; -Орлон ажиллах ажилтныг томилон ажиллуулах; -Хурал, цуглааныг цахимаар зохион байгуулах; -Халдвар хамгааллын дэглэм сахих.
Ажлын байрны горим	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	-Халдвар хамгааллын дэглэм сахих; -"QR" код байршуулан ажилтан, албан хаагч, зайлшгүй шаардлагаар үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх.	-Ажлын тусгай горимд шилжүүлэх (уртасгасан, богиносгосон цаг, цахимаар, ээлжээр ажиллах); -Мэргэжлийн байгууллагын зөвлөмж, шаардлагыг баримтлах; -Байгууллага дээр "QR" код байршуулан ажилтан, албан хаагч, зайлшгүй шаардлагаар үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх; -Орлон ажиллах ажилтныг томилон ажиллуулах; -Хурал, цуглааныг цахимаар зохион байгуулах; -Халдвар хамгааллын дэглэм сахих.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

Зэрэглэл	Өдөр тутмын бэлэн байдал	Өндөржүүлсэн бэлэн байдал		Бүх нийтийн бэлэн байдал
Түвшин	Халдвар илрээгүй	II Зөөвөрлөгдсөн, алаг цоог тархалттай	III Халдвар голомтот тархалттай	IV Халдвар хүн амын дунд тархсан
Хуулийн этгээд	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэд мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмж, халдвар хамгааллын дэглэм сахих	<p>Хязгаарлах үйл ажиллагаа:</p> <ol style="list-style-type: none"> 1. Жагсаал, цуглаан, уралдаан тэмцээн; 2. Аялал зугаалга, хурим найр, цайллага, хүлээн авалт; 3. Баар (диско, караоке) 4. Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа; 5. Цахим болон бүх төрлийн тоглоомын газар; 6. Сургалтын төв (танхимын болон үйлдвэрлэлийн сургалт 10 хүнээс хэтрүүлэхгүй); 7. Соёл урлаг; 8. Үзвэр үйлчилгээ (нийт суудлын 30 хувиас хэтрүүлэхгүй); 9. Алжаал тайлах төв; 10. Чийрэгжүүлэх, бялдаржуулах төв (нийт хүчин чадлын 30 хувиас хэтрүүлэхгүй); 11. Саун, бассейн (нийт хүчин чадлын 30 хувиас хэтрүүлэхгүй); 12. Дэн буудал; 13. Шашны зан үйл, сүм, хийд, мөргөлийн газрууд; <p>Хязгаарлахгүй үйл ажиллагаа</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрчим хүч, дулаан, усан хангамж 2. Эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага; 3. Өмгөөлөл, нотариат; 4. Шатахуун, түлшний хангамж; 5. Хүнс, ахуйн хэрэглээний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлт, сав баглаа боодол; 6. Ариутгал, халдваргүйжүүлэлт, хог хаягдлын цэвэрлэгээ, ачилт, цуглуулалт, тээвэрлэлт; 7. Цахим банк, автомат тооцооны машин; 8. Газар тариалан, өвс тэжээл, түлшний үйлдвэрлэл, нийлүүлэлт, түгээлт, тээвэрлэлт, худалдаа; 9. Харилцаа холбоо, шуудан илгээмж; 10. Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хангах аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа (эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр); 11. Хэвлэл мэдээлэл (эрх хязгаарлах); 		

			14.Олимп, тив, дэлхий, олон улсын тэмцээний бэлтгэлээс бусад биеийн тамир, спортын арга хэмжээ (дотоод орчинд 10 хүнээс хэтрүүлэхгүй).	12.Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй харуул хамгаалалтын байгууллага; 13.Геологи, хайгуул, уул уурхай, газрын тосны олборлолт; 14.Орон сууц, нийтийн үйлчилгээний контор, сууц өмчлөгчдийн холбоо; 15.Оршууллын үйл ажиллагаа.
Тайлбар: Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагыг Улсын онцгой комисстой зөвшилцсөнөөр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.				
Хязгаарлалтаас хамаарч тавигдах шаардлага				
Ажлын горим	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	-Нэг дор 30-аас хүн цугларахгүй байх (2 метрээс доошгүй зай барих)	-Нэг дор 10-аас дээш хүн цугларахгүй байх (2 метрээс доошгүй зай барих)	Хязгаарлаагүй байгууллагын ажилтны: -ажилдаа ирэх, явах, -ажил, үүрэг гүйцэтгэх, -засвар үйлчилгээ, -үйлдвэрлэл, түгээлтийг зөвшөөрнө.
Хөдөлгөөнд оролцох цагийн хязгаарлалт	Хэвийн	07.00-00.00	07.00-22.00	07.00-21.00 (хүнсний үйлдвэрлэл, түлшний түгээлт цагийн хязгааргүй)
Хот дотор нийтийн тээврийн хэрэгсэл	Ердийн цагийн хуваариар	-Ердийн цагийн хуваариар; -Халдвар хамгааллын дэглэм сахих.	-Ердийн цагийн хуваариар; -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахих.	-Онцгой комиссын зөвшөөрсөн чиглэлд; -Цагийн хуваарийг тусгай горимд шилжүүлэх; -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахих.
Автомашин	-Автомашини улсын дугаарын хязгаарлалтын дагуу зорчих (зөвхөн нийслэлд)		Хязгаарлалтад хамаарахгүй байгууллагын ажилтан, албан хаагчид ажлын үнэмлэхтэй	-Хязгаарлалтад хамаарахгүй байгууллагын ажилтан, албан хаагчид байгууллагын тодорхойлолт, ажлын үнэмлэхтэй
Хот хоорондын авто болон төмөр зам, агаарын зорчигч тээвэр	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	-Ердийн цагийн хуваариар; -Халдвар хамгааллын дэглэм сахих.	-Цагийн тусгай горимоор; -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Халдвар хамгааллын дэглэм сахих.	-Онцгой комиссын зөвшөөрөлтэй; -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахих.
Авто тээврийн	Хэвийн (халдвар)	-Шаардлагатай тохиолдолд асуумж	-Орох, гарах тээврийн хэрэгслийг хязгаарлах;	-Үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэл

<p>шалган нэвтрүүлэх товчоо</p>	<p>хамгааллын дэглэм сахих)</p>	<p>авч нэвтрүүлэх</p>	<p>-Халдварын тархалт бүртгэгдсэн газраас “ПГУ” шинжилгээний хариуг үндэслэн асуумж авч нэвтрүүлэх; -Үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх; -Асуумж авах.</p>	
<p>Агаарын хил, авто, төмөр замын боомт</p>	<p>Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)</p>	<p>Олон улсын болон дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийг хязгаарлахгүй.</p>		
<p>Ажлын байрны горим</p>	<p>Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)</p>	<p>-Халдвар хамгааллын дэглэм сахих; -“QR” код байршуулан ажилтан, албан хаагч, үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх.</p>	<p>-Ажлын тусгай горимд (уртасгасан, богиносгосон цаг, цахимаар, ээлжээр ажиллах); -Ажилчдын ажилд ирэх, явах, цайны цагийг зөрүүлэх; -Халдвар хамгааллын дэглэм сахиулан ажиллах; -“QR” код байршуулан ажилтан, албан хаагч, үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх.</p>	<p>-Ажлын тусгай горимд шилжүүлэх (уртасгасан, богиносгосон цаг, цахимаар, ээлжээр ажиллах); -Мэргэжлийн байгууллагын зөвлөмж, шаардлагыг баримтлах; -Байгууллага дээр “QR” код байршуулан ажилтан, албан хаагч, зайлшгүй шаардлагаар үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх; -Орлон ажиллах ажилтныг томилон ажиллуулах; -Хурал, цуглааныг цахимаар зохион байгуулах; -Халдвар хамгааллын дэглэм сахих.</p>

			<p>11.Дэн буудал; 12.Шашны зан үйл, сүм, хийд, мөргөлийн газрууд; 13.Олимп, тив, дэлхий, олон улсын тэмцээний бэлтгэлээс бусад биеийн тамир, спортын арга хэмжээ (дотоод орчинд 10 хүнээс хэтрүүлэхгүй).</p>	
Хязгаарлалтаас хамаарч тавигдах шаардлага				
Хөдөлгөөнд оролцох цагийн горим	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	07.00-00.00	07.00-22.00	Гэрээс гарахгүй байх зарчмыг баримтална.
Зорчих хөдөлгөөн, үйлчилгээ авах горим	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	-Иргэд хувийн халдвар, хамгааллын дэглэм сахиж үйлчилгээ авах; -“QR” код уншуулах; -Хүн хоорондын зай барих.		-Өрхийн нэг гишүүн зөвшөөрсөн үйлчилгээг гэрт хамгийн ойр цэгээс авах; -“QR” код уншуулах; -Оршуулгын үйл ажиллагаанд зөвхөн гэр бүл, хамаатан, садны хүмүүс оролцох.
Автомашинаар зорчих	-Автомашини улсын дугаарын хязгаарлалтын дагуу зорчих (зөвхөн нийслэлд)		Хязгаарлалтад хамаарахгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн холбогдох бичиг баримттай зорчих.	-Эмнэлгийн тусламж үйлчилгээ зайлшгүй авах шаардлагатай тохиолдолд (эмнэлгийн тодорхойлолтой, өвчний онош, хавдар, диализ, жирэмсэн, гэмтэл бэртэл, яаралтай мэс засал гэх мэт); -Оршуулгын үйл ажиллагаа.
Хот дотор нийтийн тээврээр зорчих	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	Халдвар хамгааллын дэглэм сахих	-1 суудал алгасч 1 зорчигч суух; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахиx.	-Зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд зорчихгүй байх; -1 суудал алгасч суух; -Халдвар хамгааллын дэглэм сахиx.

<p>Хот хоорондын нийтийн тээврээр зорчих</p>	<p>Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)</p>	<p>-Халдварын тархалт бүртгэгдсэн газраас "ПГУ" шинжилгээний хариутай зорчих; -Тархалтгүй газраас асуумж өгч зорчих; -1 суудал алгасч 1 зорчигч суух; -Халдвар хамгааллын дэглэм сахих.</p>	<p>Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хүн "А13", "Б13" маягтай зорчих; -Оршуулгын үйл ажиллагаанд оролцох хүн эмнэлгийн нас барсны гэрчилгээ, төрөл садны холбоог батлах лавлагаатай зорчих; -1 суудал алгасч суух; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахих.</p>
<p>Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоогоор нэвтрэх</p>	<p>Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)</p>	<p>Шаардлагатай тохиолдолд асуумж өгч нэвтрэх</p>	<p>-Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, оршуулгын үйл ажиллагаанд оролцож байгаа холбогдох бичиг баримттай нэвтрэх; -Товчооны гадна ажиллаж, амьдардаг хүн байнга оршин суугаа газрын баг, хорооны тодорхойлолттой нэвтрэх; -Хязгаарлалтад хамаарахгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн холбогдох бичиг баримттай нэвтрэх; -Голомттой бүсээс зорчих хүн "ПГУ" шинжилгээний хариуг үндэслэн, эрсдэлгүй бүсээс асуумж өгч нэвтрэх.</p>
<p>Зөвлөмж</p>	<p>Халдвар хамгааллын дэглэм сахих</p>	<p>-Айлд зочлохгүй, зочин урихгүй; -Шаардлагагүй тохиолдолд Амны хаалт байнга зүүх; -Хүн хооронд 2 метрээс доошгүй зай барих; -Гараа сайтар савандаж угааж, халдваргүйжүүлж хэвших; -Олон нийтийн газар аль болох очихгүй байх; -Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар,</p>	<p>-Нэн шаардлагатай хүнс, эм, түлш, ус худалдан авахаар айл, өрхөөс 1 хүн гарах; -Айлд зочлохгүй, зочин урихгүй; -Шаардлагагүй тохиолдолд гэрээс гарахгүй; -Амны хаалт байнга зүүх; -Хүн хооронд 2 метрээс доошгүй зай барих; -Гараа сайтар савандаж угааж, халдваргүйжүүлж хэвших; -Олон нийтийн газар аль болох очихгүй байх; -Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар,</p>

зай барих;
 -Гараа сайтар савандаж угааж, халдваргүйжүүлж хэвших;
 -Олон нийтийн газар аль болох очихгүй байх;
 -Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг баримтлах;
 -Төрөөс зохион байгуулж буй халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;
 -Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд 100, 119 дүгээр утсаар зөвлөгөө авах.

зөвлөмжийг баримтлах;
 -Төрөөс зохион байгуулж буй халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;
 -Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд 100, 119 дүгээр утсаар зөвлөгөө авах.